



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 01 сарын 24-ны
өдрийн 7089 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 648

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.1, 6.3.7, 6.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ыг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар, “Мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлсон журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхэд Хороонд бүртгүүлэх тухай журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120, 2021 оны 152 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДОД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛСОН ЖУРАМ

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлно.

1.2. Хороо энэ журмын 1.3-т заасан шаардлагыг хангасан мэргэжлийн холбоотой санамж бичиг байгуулан хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.

1.3. Мэргэжлийн холбоонд дараах шаардлага тавигдана:

1.3.1. мэргэжлийн холбоо нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;

1.3.2. мэргэжлийн холбоо нь тусгай зөвшөөрөлтэй этгээдийн 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

1.3.3. салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй, гишүүддээ мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах техник хэрэгслийн болон хүний нөөцийн чадамжтай байх;

1.3.4. сургалтын хөтөлбөр боловсруулж, Хороогоор батлуулсан байх;

1.3.5. мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх.

1.4. Мэргэжлийн холбооны сонгуульт гишүүд болон гүйцэтгэх захирал дараах шаардлагыг хангасан байна:

1.4.1. насанд хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;

1.4.2. хэвийнээс бусад зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

1.4.3. Татварын албанд хувь хүний орлогын албан татварын тайланг тайлагнасан байх;

1.4.4. шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй байх;

1.4.5. Эрүүгийн хуульд заасан залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн эсрэг гэмт хэргүүдэд холбогдоогүй байх.

1.5. Мэргэжлийн холбоо нь Хорооны санал, дүгнэлтийг үндэслэн дүрэм болон дараах журмуудыг батална:

1.5.1. гишүүнээр элсүүлэхэд тавих шаардлага, гишүүнчлэлийн хураамж, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах журам;

1.5.2. гишүүд, тэдгээрийн брокер, агент, эсхүл борлуулалтын ажилтны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм;

1.5.3. гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих болон гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам;

1.5.4. мэргэжлийн холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам;

1.5.5. гишүүдэд сургалт явуулах, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах журам.

1.6.Мэргэжлийн холбоо нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

1.6.1.хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг мөрдөх;

1.6.2.гишүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн санал санаачилгыг дэмжих:

1.6.3.гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалт, тайлагнал ил тод нээлттэй байх;

1.6.4.зах зээлийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө судалгаа шинжилгээнд суурилсан байх.